ТӨРИЙН БАНК

ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

# АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЦАХИМ ЗЭЭЛИЙН БАРААНЫ НЭХЭМЖЛЭЛ ҮҮСГЭХ ЗААВАР

- БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧИД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА




2024 он

# БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ НЭХЭМЖЛЭЛ БҮРТГЭХ ЗААВАР

АЛХАМ 1. Банкны вэб сайтад (www.statebank.mn) байршуулсан “Нэхэмжлэл үүсгэх портал”-аар нэвтэрнэ.




Нэхэмжлэл үүсгэх портал

Банкнаас бүртгэлтэй и-мэйл хаягт илгээсэн нэвтрэх нэр, нууц үгээр нэвтрэнэ.



# БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ НЭХЭМЖЛЭЛ БҮРТГЭХ ЗААВАР
# БАРААНЫ КАТАЛОГИ ҮҮСГЭХ

## АЛХАМ 2. Барааны нэхэмжлэл үүсгэх портал нь “Нэхэмжлэл үүсгэх”, “Нэхэмжлэлийн жагсаалт”, “Барааны каталоги” зэрэг цэстэй байна.

Барааны нэхэмжлэл үүсгэхийн тулд тухайн барааг “Барааны каталоги”-д бүртгэсэн байна.
Барааг бүртгэхэд тухайн барааны 6 төрлийн мэдээлэл бүртгэнэ.










- Лизингийн төрлийг сонгоно.
- Банкны зээлээр худалдан авах боломжтой барааны төрлөөс сонгоно.
  - Цахилгаан бараа, тавилга
  - Гар утас, таблет
  - Бусад бараа бүтээгдэхүүн
  - Цахилгаан скүүтер, унадаг дугуй
  - Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж
  - Агаар, хөрсний бохирдол бууруулах тоног төхөөрөмж
- Барааны нэршилийг бичнэ.
  /Зурагт, хөргөч, хөлдөөгч, угаалгын машин гэх мэт/
- Барааны загварын кодыг бичнэ.
  /4TC65FJ1X  KRF-180, BCD-216STPT гэх мэт /
- Барааны брендийн нэршилийг бичнэ.
  /SONY, SHARP, SAMSUNGгэх мэт /
- Барааны өнгийг оруулна.

Лизингийн төрөл: **НОГООН**




Дараах төрлийн барааг “Ногоон” төрлөөр ангилна.
- Цахилгаан бараа тавилга: “А+”-ээс дээш цахилгааны хэмнэлттэй цахилгаан бараа тус ангилалд хамаарна.
- Бүх төрлийн унадаг дугуй, цахилгаан скүүтер: Бүх төрлийн унадаг дугуй, цахилгаан дугуй, цахилгаан скүүтер тус ангилалд хамаарна.
- Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж:  /Нарны үүсгүүр, салхин сэнс, усны эрчим хүчний төхөөрөмж зэрэг хамаарна/
- Агаар, хөрсний бохирдол бууруулах тоног төхөөрмж: /Хийн болон цахилгаан халаагуур, сайжруулсан зуух, агаар цэвэршүүлэгч, бага оврын цэвэрлэх байгууламж, хог хаягдал дахин боловсруулах тоног төхөөрөмж, дулаалгын материал зэрэг хамаарна

Лизингийн төрөл: **ЭНГИЙН**




Дараах төрлийн барааг “Энгийн” төрлөөр ангилна.
- Цахилгаан бараа тавилга: Бүх төрлийн цахилгаан бараа, компьютер, төхөөрөмж, тавилга тус ангилалд хамаарна.
- Гар утас, таблет: Бүх төрлийн гар утас, таблет тус ангилалд хамаарна.
- Бусад бараа бүтээгдэхүүн: Дээрх 2 төрөлд хамаарахгүй 1 жилээс дээш эдэлгээтэй бараа бүтээгдэхүүн тус ангилалд хамаарна.

# БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ НЭХЭМЖЛЭЛ БҮРТГЭХ ЗААВАР

# НЭХЭМЖЛЭЛ ҮҮСГЭХ

## АЛХАМ 3. Барааг каталогид бүртгэсний дараа тухайн барааны нэхэмжлэл үүсгэх боломжтой болно. Нэхэмжлэл үүсгэхийн тул “Нэхэмжлэл үүсгэх” цэсээр орно.

Тухайн барааг Төрийн банкны зээлээр авахыг хүссэн харилцагчийн регистрийн дугаарыг оруулна. Зөв РД оруулсан бол харилцагчийн овог, нэрийн мэдээлэл харагдана.

“Ногоон” бараа ангиллаар каталогид бүртгэгдсэн барааны нэхэмжлэл үүсгэх бол чеклэнэ.

Барааг хүлээн авах хүний мэдээллийг оруулна.




Барааны төрөл сонголтод “Эрчим хүчний хэмнэлттэй бараа эсэх” чек хийгдээгүй бол

- Цахилгаан бараа, тавилга
- Гар утас, таблет
- Бусад бараа бүтээгдэхүүн

“Эрчим хүчний хэмнэлттэй бараа эсэх” чек хийгдсэн бол

- Цахилгаан бараа, тавилга
- Цахилгаан мотоцил, скүүтер
- Бүх төрлийн унадаг дугуй
- Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж
- Агаар, хөрсний бохирдол бууруулахад чиглэсэн тоног төхөөрөмж зэрэг сонголтууд харагдахаас худалдан авах бараанд тохирох төрлийг сонгоно.

Барааг каталогит нэмсэн, “Барааны төрөл” зөв сонгогдсон бол “Бараа” сонголтын барааны жагсаалтад тухайн бараа нэмэгдсэн байна.

Барааны өнгийн энд өөрчлөх боломжгүй бөгөөд каталоги үүсгэхэд оруулсан өнгөөр харагдана.

Нэхэмжлэл үүсгэж буй барааны нэгжийн үнийг уг талбарт оруулна.

Нэхэмжлэлд орох тухайн барааны тоо, ширхэгийг оруулна




Нэхэмжлэлд 1-ээс олон төрлийн бараа оруулах тохиолдолд “Бараа нэмэх” товч дарж бараа нэмнэ.
Нэг нэхэмжлэлд зөвхөн 1 төрлийн бараа байх боломжтой.

# БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ НЭХЭМЖЛЭЛ БҮРТГЭХ ЗААВАР
# НЭХЭМЖЛЭЛ

Барааны мэдээлэл болон худалдан авагчийн мэдээллийг бүрэн гүйцэт оруулан “Нэхэмжлэл үүсгэх” товч дарснаар барааны нэхэмжлэл үүснэ.

Худалдан авагч 12 оронтой нэхэмжлэлийн дугаарыг ашиглан Гялсбанк 3.0 ашиглан зээлийн хүсэлт гаргана.

Нэхэмжлэлд үүсгэсэн огноо болон хүчингүй болгох огнооны мэдээлэл харагдана. Цахим нэхэмлэл нь 48 цагийн хугацаанд хүчинтэй байна.



Нэхэмжлэлийн дэлгэрэнгүй

Нэхэмжлэлийн дугаар: L241217612338

Нэхэмжлэл үүссэн огноо: 2024-12-17 11:33:17

Хүчингүй болох огноо: 2024-12-19 11:33:17

**Худалдагч талын мэдээлэл**

| | |
|---|---|
| Нэр: | Дэлгүүр 1 |
| Хаяг: | УБ, ХУД, Гэгээнтэн |
| Утасны дугаар: | 9905-5645 |
| И-мэйл хаяг: | mungunbagana.b@statebank.mn |
| Веб сайт: | - |

**Худалдан авагчийн мэдээлэл**

| | |
|---|---|
| Овог: | БУЯНЖАРГАЛ |
| Нэр: | МӨНГӨНБАГАНА |
| Регистрийн дугаар: | Н*8*1*0*7* |
| Утасны дугаар: | 9999-9999 |
| И-мэйл хаяг: | test@test |

**Хүргэлтийн мэдээлэл**

| | |
|---|---|
| Хүлээн авах хүний нэр: | Баяр |
| Хүлээн авах хүний утасны дугаар: | 99999999 |
| Хүргүүлэх хаяг: | УБ хот, ХУД, 4-р хороо, Наадамчдын зам гудамж, Ханбогд, 305 байр, 10 тоот |

**Барааны мэдээлэл**

| № | Код | Нэр | Бренд | Өнгө | Лизинг төрөл | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | SC360H | Хөргөгч | SHARP | Саарал | Энгийн | 1 | 1,250,000 | 1,250,000 |
| | | | | | **Нийт** | **1** | **1,250,000₮** | **1,250,000₮** |

**Барааны баталгааны мэдээлэл:**
Дээрх худалдан авч буй бараа нь Бэлтгэн нийлүүлэгч байгууллагын Төрийн банктай байгуулсан хамтран ажиллах гэрээ /ахуйн хэрэглээний зээл/-ийн дагуу баталгаат засварын хугацаатай болно.

**Санамж:**
Нэхэмжлэлийн хүчингүй болох огноонoос өмнө зээлийн хүсэлтийг шийдвэрлүүлсэн байх ёстойг анхаарна уу.

Худалдагч тал болон худалдан авагч талын нэр, хаяг, утасны дугаар, и-мэйл хаяг зэрэг мэдээлэл нэхэмжлэлд тусгагдана.

Худалдан авагчаас барааг хүлээн авах хүний мэдээлэл болон хүргэлт хийх хаягийн дэлгэрэнгүй мэдээллийг авах бөгөөд тус мэдээлэл нэхэмжлэлд тусгагдана.

Барааны мэдээлэл хэсэгт худалдан авах бараа тус бүрийн нэр, бренд, код, өнгө, тоо ширхэг, нэгжийн болон нийт үнэ зэрэг мэдээлэл тусгагдана.

Энэ хэсэгт барааны баталгааны ерөнхий мэдээлэл болон нэхэмжлэлийн хүчинтэй хугацаатай холбоотой санамж мэдээлэл тусгагдана.